

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2024 оны 05 дугаар сарын 15-ны “Лхагва” гаратт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
1	Төрийн ажлын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд дараах ажлуудыг шуурхай зохион байгуулах. Үүнд: - Инженерийн шугам, сүлжээний бэлэн байдлыг сайтар хангах; - Хот нийтийн аж ахуйн чиг үүргийн хүрээнд тохижилт, хог хаягдлын цэвэрлэгээ, үйлчилгээг батлагдсан графикт хуваарийн дагуу зохион байгуулж, түүвэр цэвэрлэгээ хийх; - Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг батлагдсан хуваарийн дагуу шуурхай зохион байгуулах;	Инженерийн дэд бүтцийн байгууллагууд,  Багахангай тохижилт ОНӨААТҮГ,  СТСХ, ХААА,
2	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнийг дагалдаж байгаа хуулийн төслүүдийн талаар танилцуулах ажлыг зохион байгуулахтай холбогдуулан дараах бэлтгэл ажлыг хангах. Үүнд: 1. Эдийн засгийн нөхцөл; 2. Эрх зүйн орчин; 3. Засаглалын бодлого.	ЗДО Б.Болормаа, СТСХ, Татварын хэлтэс,  ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ТЗУХ
3	Нутгийн захиргааны байгууллагуудад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх ажлыг эрчимжүүлж, одоо байгаа авто машинуудын насжилтын талаарх нарийвчилсан судалгааг гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ авч танилцуулах.	СТСХ, Нийт байгууллагууд
4	Үндэсний их баяр наадам болон Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ЗДТГ, нийт байгууллагууд, НХХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
5	Барилгын ажлууд эхэлсэнтэй холбогдуулан тухайн орчны хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайтар хангуулж, хяналт тавих.	ТХҮХ, Ажлын хэсэг
6	Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сайтар хангаж, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлуудыг эрчимжүүлэх.	СТСХ, Татварын хэлтэс
7	Дүүргийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор архины хамааралтай иргэдийн асуудлыг цэгцлэх арга хэмжээ зохион байгуулж, иргэдийн эрүүл, аюулгүй, орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажиллах.	Цагдаагийн хэлтэс
8	Дүүргийн хэмжээнд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдал болон хийж хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Удирдах ажилтнуудын Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах.	ОБХ

9	Явган хүний зам дээр авто машин байршуулдаг иргэдэд хотын соёл, дүрэм, журам мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.	Цагдаагийн хэлтсийн Замын Цагдаагийн хэсэг
10	“Улаанбаатар Марафон 2024” олон улсын гүйлтэд байгууллага хамт олноо идэвхтэй оролцуулж, олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлуудыг зохион байгуулах.	Нийт байгууллагууд
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
11	Өөрийн эзэмшлийн газраас гаднах хэсэгт ил задгай хаягдал эд зүйл буулгасан зөрчлийг арилгуулах арга хэмжээг яаралтай зохион байгуулах.	Цагдаагийн хэлтэс, ГЗБА
12	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/367 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрлийн болон бусад шон дээгүүр татсан кабел утсыг цэгцлэх ажлуудыг шуурхай зохион байгуулах хүрээнд байгуулагдсан Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, төлөвлөгөө гарган ажиллах.	ТХҮХ, Ажлын хэсэг
13	“Гэрэлт гудамж”-ны доорх лоткины тагийг сольж, хашааг буулгах ажлыг шуурхай зохион байгуулах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Илч-Орд ОНӨААТҮГ
14	2024 оны 05 дугаар сарын 11-нд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” тохиож байгаатай холбогдуулан мод тарих ажлыг зохион байгуулах, “Өрх бүр нэг мод” аяныг өрнүүлэх.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, нийт байгууллагууд, Хороод
15	“Service center” дэд бүтцийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгч шалгарсантай холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ
16	Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн санхүүжилтээр санхүүжиж буй ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллах.	Холбогдох байгууллагууд
17	Орчны аюулгүй байдлын үзлэгийн үеэр өгөгдсөн үүргийг бүрэн биелүүлж ажиллах.	Холбогдох байгууллагууд
18	“Фокус бүлэг”-ийн уулзалтын ажлыг эрчимжүүлэх.	Бодлогын хэлтсүүд, холбогдох байгууллагууд
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
19	Дүүргийн ОНХС-ийн санхүүжилтээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын саналд ажилтан, албан хаагчид, иргэдийг идэвхтэй оролцуулахад анхаарч, хамтран ажиллах.	СТСХ, Нийт байгууллага
20	УБЗАА-наас зарласан “Хотоо угаая” аяны хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, авто замын хайс хашлага, хөшөө дурсгал, хүүхдийн тоглоомын талбай, хогийн сав, сандал зэргийг үе шаттайгаар цэвэрлэх, ААНБ-ууд орчны 50м газрын цэвэрлэгээг тогтмолжуулах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ААНБ-ууд
21	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдэрч гэмтсэн эд хөрөнгийг засварлаж, өнгө үзэмжийг сайжруулан сэргээх ажлыг яаралтай зохион байгуулах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
22	2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Налайх дүүрэгт зохион байгуулагдах “Хүүхдийн эрхийг хамгаалах Хууль зүйн хороод”-ын гишүүдийн Ажлын хэсгийн хуралд дүүргийн Засаг даргын захирамжаар баталгаажсан гишүүд идэвхтэй хамрагдах.	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Ажлын хэсэг

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**